




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН  
ХЭЛТЭС



# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

## 2024 XII



[www.1212.mn](http://www.1212.mn)



Улаанбаатар хот  
2024 он

### I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).


### II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- \* урьдчилсан гүйцэтгэл
- \*\* дахин











**III.** Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

### IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000		
сая	=10 <sup>6</sup>		
тэрбум	=10 <sup>9</sup>		
их наяд	=10 <sup>12</sup>		
мян	мянга		
%	хувь		
мм	миллиметр		
см	сантиметр		
дм	дециметр		
м	метр		
км	километр		
м <sup>2</sup>	метр квадрат		
дм <sup>2</sup>	дециметр квадрат		
км <sup>2</sup>	километр квадрат		
м <sup>3</sup>	метр куб		
га	гектар		
мл	миллилитр		
л	литр		
г	грамм		
кг	килограмм		
цн	центнер		
т	тонн		
Вт	ватт		
кВт.ц	киловатт цаг		
кал	калори		
ккал	килокалори		
Гкал	гигакалори(=10 <sup>9</sup> калори)		
с	секунд		
мин	минут		
мкг/м <sup>3</sup>	микрограмм метр куб		
м/с	метр секунд		
ш	ширхэг		
х.д.х	хэвлэлийн	даралтат	хуудас



## ГАРЧИГ

	ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2020-2024 ОН	1
	ЭРҮҮЛ МЭНД	2
	НИЙГМИЙН ДААТГАЛ	6
	ХАЛАМЖ	9
	ГЭМТ ХЭРЭГ	11
	ДҮҮРГИЙН ТӨСӨВ	15
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	19
	АЖ ҮЙЛДВЭР	24
	ХӨДӨӨ АЖ АХУЙ	30
	ЗАХИРГААНЫ МЭДЭЭ	32

ХҮСНЭГТ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2024 онд

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
Шинээр төрсөн хүүхэд		хүн	4 840 ↑5.6	4 806 ↑0.5	4 866 ↓1.2	5 059 ↑4.0	4 800 ↓5.1
Халдварт өвчнөөр өвчлөгчид		хүн	1 281 ↓94.1	25 115 ↑19.6*	25 265 ↑0.6	2 112 ↓91.6	1 820 ↓13.8
Бүртгэгдсэн гэмт хэрэг		тоо	1 650 ↓19.7	2 045 ↑23.9	3 179 ↑55.4	3 974 ↑25.0	5 101 ↑28.3
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		хувь	1.9 ↓3.1	14.8 ↑12.9	0.9 ↓2.0	0.8 ↓0.1	1.3 ↑0.5
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	төгрөг	2 849 ↑4.4	2 848 ↓0.03	3 431 ↑20.4	3 421 ↓0.02	3 418 ↓0.1
	Юань (БНХАУ)	төгрөг	436 ↑12.1	447 ↑2.5	491 ↑9.8	479 ↓2.4	468 ↓2.3
	Рубль (ОХУ)	төгрөг	38 ↓11.6	39 ↑2.6	52 ↑33.3	38 ↓26.9	34.0 ↓10.5
Хан-Уул дүүргийн төсвийн орлого		сая төгрөг	116 020.3 ↑33.5	298 813.4 ↑57.6	324 956.1 ↑8.7	481 362.2 ↑48.1	910 251.2 ↑89.1
Хан-Уул дүүргийн төсвийн зарлага		сая төгрөг	105 238.2 ↑30.1	169 927.8 ↑85.3	214 051.4 ↑26.9	437 977.3 ↑104.6	978 585.6 ↑123.4

Тайлбар: Өмнөх онтой харьцуулсан



Эерэг хандлага,  
өөрчлөлт

Сөрөг хандлага,  
өөрчлөлт



## ЭРҮҮЛ МЭНД, 2024 оны 12 дугаар сар

МОНГОЛ  
УЛАС



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2023 2 112

2024 1 820

13.8%



Амаржсан эх



2023

5 023

5.6%



2024

4 743

Шинэ төрсөн хүүхэд

2023

5 059

5.1%



2024

4 800



## ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2024 онд 1820 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 292 хүнээр (13.8%) буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 38.9 хувийг салхин цэцэг, 10.2 хувийг гар хөл, амны өвчин, 14.0 хувийг цусан суулга, 9.5 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 6.1 хувийг тэмбүү, 4.1 хувийг заг хүйтэн, 0.7 хувийг вируст гепатит, 1.0 хувийг трихомониаз, 15.5 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

### ХҮСНЭГТ 2. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, 2024 онд


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 I-XII	2023 I-XII	2024 I-XII	Өсөлт, бууралт 2024/2023	
					тоо/нэгж	хувь
<b>НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>Бодит тоо 10000 хүнд</b>	<b>25 265 1 246.3</b>	<b>2 112 94.3</b>	<b>1 820 73.3</b>	<b>-292 -21.0</b>	<b>-13.8</b>
Вируст гепатит	Бодит тоо 10000 хүнд	14 0.7	24 1.1	13 0.5	-11 -0.6	-45.8
Цусан суулга	Бодит тоо 10000 хүнд	167 8.2	214 9.6	255 10.3	41 0.7	19.1
Улаан эсэргэнэ	Бодит тоо 10000 хүнд	12 0.6	142 6.3	66 2.7	-76 -3.6	-53.5
Сальмонеллэз	Бодит тоо 10000 хүнд	18 0.9	28 1.2	50 2.0	22 0.8	78.6
Салхин цэцэг	Бодит тоо 10000 хүнд	222 11.0	915 40.8	708 28.5	-207 -12.3	-22.6
Гахайн хавдар	Бодит тоо 10000 хүнд	1 0.0	22 1.0	32 1.3	10 0.3	45.4
Ёлом	Бодит тоо 10000 хүнд	6 0.3	8 0.4	20 0.8	12 0.4	1.5*
Гар хөл, амны өвчин	Бодит тоо 10000 хүнд	126 6.2	371 16.6	185 7.4	-186 -9.2	-50.1
Тэмбүү	Бодит тоо 10000 хүнд	83 4.1	124 5.5	111 4.5	-13 -1.0	-10.5
Заг хүйтэн	Бодит тоо 10000 хүнд	32 1.6	46 2.1	75 3.0	29 0.9	63.0
Трихомониаз	Бодит тоо 10000 хүнд	13 0.6	21 0.9	19 0.8	-2 -0.1	9.5
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо 10000 хүнд	169 8.3	163 7.3	173 7.0	10 -0.3	6.1
Мөөгөнцөр	Бодит тоо 10000 хүнд	0 0	0 0	0 -	- -	-
Ковид 19	Бодит тоо 10000 хүнд	24 398 1203.5	0 0	1 -	1 -	-
Бусад өвчлөл	Бодит тоо 10000 хүнд	4 0.0	34 1.5	112 4.5	78 3.0	2.3*

\*дахин

ЗУРАГ 1. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД



ЗУРАГ 2. АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД



2024 онд эхийн эндэгдэл гараагүй бол нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеэс 16 хүүхдээр нэмэгдсэн, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 хүүхдээр буурсан байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, 2024 онд

Үзүүлэлт	2022 I-XII	2023 I-XII	2024 I-XII	$\frac{2024}{2023}$ %
Амаржсан эхийн тоо	4 807	5 023	4 743	-5.6
Амьд төрсөн хүүхэд	4 866	5 059	4 800	-5.1
Төрөхийн улмаас эндсэн эх	3	1	0	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	37	37	53	43.2
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	9	7	6	-14.3

\*-дахин

Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв

**Ойлголт, тодорхойлолт:**

**Амьд төрөлт:** Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

**Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эндсэн эх:** Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.






## НИЙГМИЙН ДААТГАЛ 2024 оны 12 сард

НИЙГМИЙН ДААТГАЛ

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, сая төгрөг




\* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

### НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД



### ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД





## НИЙГМИЙН ДААТГАЛ

2024 онд дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 340.0 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 353.3 тэрбум төгрөгөөр (51.0%) дутуу бүрдсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61.3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

### ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан тус бүрээр, 2024 онд

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2023 I-XII	2024 I-XII	2023 I-XII	2024 I-XII	2023 I-XII	2024 I-XII
Нийт	542 936.7	693 325.3	598 923.5	340 043.8	110.3	49.0
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	386 615.0	593 292.2	425 770.9	293 508.8	110.1	49.5
Тэтгэмжийн сангийн орлого	35 174.9	48 614.5	39 368.9	24 602.9	111.9	50.6
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	30 132.7	32 802.8	34 825.6	2 655.9	115.6	8.1
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	7 497.8	18 614.9	15 441.8	19 275.3	206.0	103.5
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	83 516.3	0.9	83 516.3	0.9	100.0	100.0


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 86.3 хувийг тэтгэврийн даатгалын санд, 7.4 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 0.7 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 5.6 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 22571 хүнд 239.3 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3579 хүнд 24.9 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1138 хүнд 7.7 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1657 хүнд 26.4 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 11840 хүнд 5.4 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 4540 хүнд 18.2 тэрбум төгрөгийг, 830 хүнд оршуулгын тэтгэмж 1.6 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.


ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 157 хүнд 1788.2 сая

төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 17 хүнд 240.9 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 191 хүнд 392.1 сая төгрөгийг тус тус олгосон байна. ҮОМШӨ-ний бусад зардалд 25 хүнд 84.2 сая төгрөгийг, ажилгүйдлийн тэтгэмж авсан 8743 хүнд 19.3 тэрбум төгрөг зарцуулжээ.

ЗУРАГ 5. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төг



ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО



Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 86.3 хувийг тэтгэврийн, 7.4 хувийг тэтгэмжийн, 0.7 хувийг ҮОМШӨ-ний, 5.6 хувийг ажилгүйдлийн зардал эзэлж байна.

**Ойлголт, тодорхойлолт:**

**Нийгмийн даатгал** нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

**Нийгмийн даатгалын** сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Даатгуулагч** гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

**Тэтгэвэр** гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

**Тэтгэмж** нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2024 онд нийгмийн халамжийн сангийн олголтын мэдээгээр нийт 21.4 хувь нь нийгмийн халамжийн сан, 71.7 хувь нь хүүхдийн мөнгө, 1.0 хувь нь алдарт эхийн одон, 1.2 нь насны хишиг, 0.5 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл, хүүхэдтэй, 3.4 хувь нь цалинтай ээж хөтөлбөр, 0.2 хувь нь хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, 0.6 хувь нь ахмад цолтон, өрх толгойлсон эцэг эх, онцгой тохиолдлын орлогод тус тус хуваарилсан байна.

Харин зарлагын 71.7 хувь нь хүүхдийн мөнгө буюу нийт 102257 хүнд, 597 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 19028 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

### ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2024 онд, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
<b>Нийгмийн халамжийн сангийн орлого</b>	<b>163 144.7</b>	
Улсын төсвийн санхүүжилтийн орлого	163 144.7	
Нийгмийн халамжийн сан	34 879.6	
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	844.8	
Алдарт эхийн одонгийн тусламж	1 545.7	
Насны хишиг	1 988.5	
Хүүхдийн мөнгө	117 059.4	
Цалинтай ээж хөтөлбөр	5 542.7	
Ахмад цолтон ахмадын хөнгөлөлт, тусламж	158.6	
Өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж	825.9	
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	38.4	
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	261.1	
<b>Зарлагын нийт дүн</b>	<b>163 144.7</b>	<b>186 647</b>
Нийгмийн халамжийн сан	34 879.6	36 469
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	7 213.4	19 026
Алдарт эхийн одонгийн тусламж	1 545.7	13 113
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	158.6	597
Хүүхдийн мөнгө	117 059.4	102 257
Насны хишиг	1 988.5	13 207
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	38.4	32
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	261.1	1 946

**Ойлголт, тодорхойлолт:**

**Нийгмийн халамж** гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

**Нийгмийн халамжийн дэмжлэг**, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн" гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлн



## ГЭМТ ХЭРЭГ

2024 онд дүүргийн нутаг дэвсгэрт 5101 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1127 хэргээр 28.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр


Төрөл	2023 I-XII	2024 I-XII	Үүнээс: Цагдаагийн хэлтсээр		Өсөлт, бууралт	
			I	II	Тоо	Хувь
Нийт	3 974	5 101	3 282	1 819	1 127	28.4

### ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, 2024 онд

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2024/2023	
	2022 I-XII	2023 I-XII	2024 I-XII	Тоо	Хувь
<b>Дүүргийн дүн</b>	<b>3 179</b>	<b>3 974</b>	<b>5 101</b>	<b>1 127</b>	<b>28.4</b>
Хүнийг алах /10.1/	15	13	14	-1	-7.7
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх /10.4/	34	53	51	-2	-3.8
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11.7/	700	621	614	3	60.0
Хүчиндэх /12.1/	36	37	44	7	19.0
Хулгайлах /17.1/	588	431	996	565	2.3*
Малын хулгай	19	11	3	-8	-72.7
Дээрэмдэх /17.2/	18	13	40	27	3.0*
Залилах /17.3/	1174	2 059	2 370	311	15.1
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах /20.16/	6	1	-	-1	-
ХАБТХАЖЭ* /27.1-27.11/	100	109	186	77	71.0
Бусад	489	626	783	157	25.1

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 12.0 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бол 46.5 хувийг залилах, 19.5 хувийг хулгайлах, 3.6 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих, 0.9 хувийг хүчиндэх, 0.8 хувийг дээрэм, 0.3 хувийг хүнийг алах, 1.0 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 15.3 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ

Дүүрэг	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2024/2023	
	2022 I-XII	2023 I-XII	2024 I-XII	Тоо	Хувь
Хан-Уул	3 179	3 974	5 101	1 127	28.4
Үүнээс: Цагдаагийн хэлтсээр					
I хэлтэс	2 013	2 598	3 282	684	26.3
II хэлтэс	1 166	1 376	1 819	443	32.2

Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 64.3 хувь нь цагдаагийн I хэлтсийн харьяа хороодын нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

Дүүргийн хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон 4999 иргэн хохирсоны 2476 (49.5%) нь эмэгтэйчүүд байсан бол 23 (0.5%) нь 7 хүртэлх насны хүүхэд, 110 (2.2%) нь 8-13 насны хүүхэд, 237 (4.7%) нь 14-17 насны хүүхдүүд хохирсон байна.

Гэмт хэргийн улмаас 746 хүн гэмтэж осолдон, 80 хүн нас барж, төр ард иргэдэд 128821.6 сая төгрөгийн хохирол учруулсны 86338.2(67.0%) сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2024 онд тус дүүргийн 15 дугаар хороонд 652 гэмт хэрэг гарч хамгийн өндөр, 7 хорооны нутаг дэвсгэрт хамгийн бага буюу 31 гэмт хэрэг гарсан байна

**Ойлголт, тодорхойлолт:**

**Гэмт хэрэг:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

**16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг:** Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

**Хохирогч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

**Гэмт хэргийн хохирол:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

**Яллагдагч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.




ХҮСНЭГТ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, төрлөөр

Хороод	Нийт дүн	Хүнийг алах /10.1/	Хүнийг амиа хорлох нөхцөлд байдалд хүргэх /10.4/	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11.7/	Хүчиндэх /12.1/	Хулгайлах /17.1/	Үүнээс			Дээрэмдэх /17.2/	Залилан мэхлэх /17.3/	Малын хулгай /17.2/	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг /27.1-27.11/	Бусад
							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай					
1-р хороо	241			17	2	44	22	2	18	2	122		8	46
2-р хороо	238	3	2	28	1	28	21		5	2	129		6	39
3-р хороо	415	1	1	58	8	58	47		8	3	213		16	57
4-р хороо	183		2	20	2	39	29		6		74		14	32
5-р хороо	73	1		6		16	6		9		34		4	12
6-р хороо	83		2	13	2	17	9	1	4	2	39		2	6
7-р хороо	31			4	2	8	6		1		11		3	3
8-р хороо	150	1	4	20	3	32	18	1	5		53		14	23
9-р хороо	67		1	17	4	14	8	1	2		20		2	9
10-р хороо	120		3	19	1	20	15		2	1	52		10	14
11-р хороо	370	1	5	56	2	61	45		11	5	158		11	71
12-р хороо	58		2	8	1	16	10				20	1	2	8
13-р хороо	43	1	2	5		7	4		1		16	1	5	6
14-р хороо	96	2	2	17	1	17	10	1		1	19	1	7	29
15-р хороо	652	1	1	92	2	176	113		53	7	236		26	111
16-р хороо	106	2	1	20	2	32	23	1	6	1	32		6	10
17-р хороо	236	1	2	20	1	61	55		2	3	102		10	36
18-р хороо	263		2	21		80	72		6	1	124		3	32
19-р хороо	224		6	28	2	38	26		10	3	108		5	34
20-р хороо	574		4	53	2	35	29		4	2	381		7	90
21-р хороо	238			18	2	52	36	2	13	3	125		9	29
22-р хороо	69		3	11	1	20	13		1	1	26		1	6
23-р хороо	216		2	22	1	45	35	1	1	2	103		7	34
24-р хороо	237		3	30	2	53	42	1	10	1	109		5	34
25-р хороо	118		1	11		27	20		6		64		3	12
<b>Нийт дүн</b>	<b>5101</b>	<b>14</b>	<b>51</b>	<b>614</b>	<b>44</b>	<b>996</b>	<b>714</b>	<b>11</b>	<b>184</b>	<b>40</b>	<b>2370</b>	<b>3</b>	<b>186</b>	<b>783</b>




## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2024 онд, тэрбум төгрөг


Ажлын  
Хүрээ



### Хан-Уул дүүргийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын бүтэц



■ Татварын орлого  
■ Татварын бус орлого




■ Урсгал зардал  
■ Хөрөнгийн зардал



## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2024 оны байдлаар 910.2 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 54.9 (5.7%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2023 оноос 89.1 хувиар өссөн байна. Төсвийн нийт орлогын 48.8 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 51.2 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) эзэлж байна.

ЗУРАГ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг



Татварын орлогын хэмжээ 444.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 32.6(6.8%) тэрбум төгрөгөөр , татварын бус орлого 465.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 22.3(4.6%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 10. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2024 онд, сая.төгрөг

Төсвийн орлого			Үүнээс:						
Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Татварын орлого			Татварын бус орлого			
			Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	
Дүн	910251.2	94.3	-54957.4	444646.9	93.2	-32608.5	465604.3	95.4	-22348.9

Орлогын албан татвар төлөвлөснөөс 6.9 тэрбум төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 26.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн бол хөрөнгийн албан татвар 1.1 тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 11. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2024 онд, сая.төг


Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ хувь	Зөрүү
Орон нутгийн орлого	965 208.6	910 251.2	94.3	-54 957.4
1.Татварын орлогын дүн	477 255.4	444 646.9	93.2	-32 608.5
1.1 Орлогын албан татвар	374 725.8	367 844.6	98.2	-6 881.2
Хувь хүний орлогын албан татвар	374 725.8	367 844.6	98.2	-6 881.2
1.2 Хөрөнгийн албан татвар	25 652.9	26 759.3	104.3	1 106.3
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	76 876.7	50 043.0	65.1	-26 833.6
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	39 535.9	16 523.8	41.8	-23 012.0
Улсын тэмдэгтийн хураамж	36 442.7	13 299.4	36.5	-23 143.3
Ашигт малтмал ашигласны төлбөр	163.2	245.6	150.5	82.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2 930.0	2 978.8	101.7	48.8
1.3.2 Газрын төлбөр	37 300.0	33 459.8	89.7	-3 840.2
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	40.8	59.4	145.5	18.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	40.8	59.4	145.5	18.6
2.Татварын бус орлогын дүн	487 953.2	465 604.3	95.4	-22 348.9
2.1 Нийтлэг татварын бус орлого	3 729.4	8 884.7	238.2	5 155.2
Торгуулийн орлого	3 000.0	8 321.6	277.4	5 321.6
Төсөвт байгууллагын өөрийн орлого*	688.2	540.0	78.5	-148.2
Бусад орлого	41.2	23.1	56.0	-18.1
2.2 Тусламжийн орлого	480 986.1	453 619.0	94.3	-27 367.1
2.3 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3 237.7	3 100.6	95.8	-137.1

\*Төсөвт байгууллагын өөрийн орлого нь үндсэн болон туслах орлогын нийлбэр дүн

2024 онд орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 978.6(96.8%) тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 32.1(3.2%) тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 1.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.1 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 98.6 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

ЗУРАГ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



ХҮСНЭГТ 12. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2024 онд, сая.төг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	910 251.2	1 010 674.5	978 585.6	96.8	-32 088.9	-68 334.4

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 10.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол шинээр өглөг үүсээгүй, тухайн сард 10.7 тэрбум төгрөг хасагдаж, сарын эцэст үлдэгдэлгүй болсон байна.

ХҮСНЭГТ 13. ӨГЛӨГ, 2024 онд, сая.төг

	12-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	12-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	10.7	0.0	10.7	0.0

**Ойлголт, тодорхойлолт:**

**Татварын орлого:** Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

**Татварын бус орлого:** Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

**Төсвийн орлого:** Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

**Урсгал зардал:** Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

**Төсвийн орлого:** Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

**Урсгал зардал:** Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.




## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өслөө.

2024 оны 12 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 9.1 хувь өссөн ба өмнөх сартай харьцуулахад 1.3 хувиар өссөн байна.

ЗУРАГ 10 . ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2024 оны 12 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 9.1 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 8.4 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 3.5 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 10.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 24.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 9.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 5.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 5.5 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 19.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 9.3 хувиар, бусад бараа үйлчилгээний үнэ 8.7 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 14 . ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2023-XII</u> 2022-XII	<u>2024-XII</u> 2023-XII	<u>2024-XII</u> 2023-XII	<u>2024-XII</u> 2024-XI
<b>Ерөнхий индекс</b>	<b>108.6</b>	<b>109.1</b>	<b>109.1</b>	<b>101.3</b>
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	112.6	108.4	108.4	102.1
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	104.6	103.5	103.5	100.2
Хувцас, бөс бараа, гутал	106.6	110.1	110.1	101.5
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	106.3	124.9	124.9	101.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	106.3	109.0	109.0	100.8
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	108.0	105.2	105.2	100.1
Тээвэр	100.4	106.6	102.6	101.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.8	102.2	102.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	103.4	105.5	105.5	100.0
Боловсролын үйлчилгээ	121.2	119.7	119.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	117.5	109.3	109.3	101.4
Даатгал, Санхүүгийн үйлчилгээ	102.8	102.3	102.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	122.4	108.7	108.7	100.1

2024 оны 12 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 405 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 45.7 хувь нь өсөж, 23.2 хувь нь буурч, 31.1 хувь нь тогтвортой байв

ХҮСНЭГТ 15. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН САРЫН ИНДЕКС, /**эерэг**, **сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт хувь	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	<b>2.1</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд алтан тариа дээдийн дээд савласан 1кг гурилын үнэ 1.6 хувиар, атар талхны үнэ 4.7 хувиар, 300 гр-ийн лапша гоймонгын үнэ 5.6 хувиар тахианы мах 3.0 хувиар, боловсруулаагүй сүүний үнэ 3.3 хувиар, бусад тосны үнэ 3.6 хувиар, усан үзэмний үнэ 6.4 хувиар, хувиар, монгол бөөрөнхий байцайны үнэ 5.6 хувиар, 936 гр-ийн Ковар компотны үнэ 3.2 хувиар, stimo гүрж ногоон цайны үнэ 2.8 хувиар, бусад хүнсний ногоо 4.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Согууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	<b>0.2</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд советское игристое 0,75 р шилтэй оргилуун дарсны үнэ 6.7 хувиар, Heineken шар айрагны үнэ 2.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	<b>1.5</b>	Энэ бүлгийн өсөлтөд 5-7 настай эрэгтэй хүүхдийн 100% даавуун оймсны үнэ 7.4 хувиар, 42-46 размерийн 100 хувь ноолууран эмэгтэй цамцны үнэ 3.3 хувиар, 0-2 насны хүүхдийн бодины үнэ 2.8 хувиар, эрэгтэй хүний ноосон малгайны үнэ 3.9 хувиар, 40-43 размерийн Өвлийн хагас түрийтэй эрэгтэй гутлын үнэ 2.9 хувиар, 10-12 насны хүүхдийн пүүзний үнэ 2.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Орон сууц, ус цахилгаан хийн болон бусад түлш	<b>1.6</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд тавилгатай 1 өрөө байрны түрээсийн төлбөр төлбөр 17,1 хувь, тавилгатай 2 өрөө байрны түрээсийн төлбөр төлбөр 10,0 хувь солонгос ханын цаас 4.4 хувиар, шуудайтай түлшний модны үнэ 1.2 хувиар өссөн нь нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	<b>0.8</b>	Энэ бүлгийн өсөлтөд 140x190 см-ийн хэрээсэн бүтээлэгний үнэ 1.5 хувиар, 30x60 см-ийн гар нүүрний алчуурны үнэ 2.4 хувиар, халуун тогооны үнэ 9.7 хувиар, 1800-2000 ватт тоос сорогчын үнэ 5.7 хувиар, 5 л-ийн никель хоолны төмөр савны үнэ 3.7 хувиар, 1.5 вольтийн хуруу зайны үнэ 2.4 хувь, kangaroo 40 гр-ийн гутлын тосны үнэ 1.4 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Эм, тариа, эинэлгийн үйлчилгээ	<b>0.1</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд Хлорфенамен, 4мг, 20x1 таблетт үнэ 1.3 хувиар, праденк хүүхдийн лааны үнэ 1.7 хувиар, халуун хэмжигчийн үнэ 3.7 үнэ 2.9 хувиар, жирэмсэний тестийн үнэ 6.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Тээвэр	<b>1.9</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд суудлын жижиг тэрэг приус автомашины үнэ 3.4 хувиар, Суудлын тэрэгний бензин хөдөлгүүрийн тос, "Mobile", 1 л, үнэ 1.5 хувиар өссөн нь нөлөөлөв.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	<b>1.4</b>	Энэ бүлгийн өсөлтөнд шилтэй сэнгүр /зоогийн газарт/ пивоны үнэ 4.8 хувиар өссөн нь нөлөөлөв.
Бусад бараа үйлчилгээ	<b>0.1</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд 14 ш котех ариун цэврийн үнэ 1.4 хувиар, бага ангийн охидын үүрдэг цүнхны үнэ 2.3 хувиар нөлөөлсөн байна.


2024 оны 12 дугаар сарын 18 -ний өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад, “Хонины мах”, ястай 3200 төгрөг, “Үхрийн мах”, ястай мах 1500, элсэн чихэр 1112 төгрөг, байцаа 800 төгрөг, 2-р зэргийн гурил 270 төгрөг, Цагаан будаа 210 төгрөг лууван 200 төгрөг, дээд зэргийн гурил, задгай сүү тус бүр 100 төгрөг, 1-р зэргийн гурил 60 төгрөгөөр тус тус өссөн бол, манжин 2000 төгрөг, төмс 400 төгрөгөөр тус тус буурсан байна. Талх чихэр” ХК-ны “Атар” талх, сонгино, польш алим, Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК-ийн бүтээгдэхүүнүүд үнийн өөрчлөлтгүй байна

ХҮСНЭГТ 16. БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн XII сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2023.XII	2024.XII	2024 2023%
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	2 400	2 400	100
Хонины мах, ястай	Кг	9 800	13 000	132.7
Үхрийн мах, ястай	Кг	14 500	16 000	110.3
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	Кг	2 950	3 050	103.4
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК, задгай	Кг	2 600	2 660	102.3
Гурил ,2-р зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	Кг	1 560	1 830	117.3
Элсэн чихэр	Кг	4 500	5 612	124.7
Төмс, монгол	Кг	2 000	1 400	70
Байцай, монгол	Кг	2 000	2 800	140
Лууван, монгол	Кг	2 800	3 000	107.1
Манжин, монгол	Кг	6 500	4 500	69.2
Сонгино, хятад	Кг	3 500	3 500	100
Цагаан будаа	Кг	6 400	6 610	103.3
Алим, Польш	Кг	8 000	8 000	100
Сүү, задгай	литр	4 000	4 100	102.5
Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК	литр	4 140	4 140	100

\*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсврага” төв

ЗУРАГ 11. НЭГ КГ ХОНИНЫ МАХНЫ дундаж үнэ, төгрөг




ЗУРАГ 12. НЭГ КГ ҮХРИЙН МАХНЫ дундаж үнэ, төгрөг



ЗУРАГ 14. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн XII сард, төгрөг







ЗУРАГ 15. НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн XII сард, төгрөг



ХҮСНЭГТ 17. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

ШТС	2023.XII.18					2024.XII.20				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Петровис	3 710	2 370	2 390	3 690	-	3 910	-	2 390	3 140	-
Магнай трейд	3 710	-	2 390	3 690	-	3 910	-	2 390	3 140	-
Сод монгол	3 710	2 315	2 390	3 490	-	3 910	-	2 390	3 140	-
Шунхлай	3 710	-	2 390	3 690	-	3 910	-	2 390	3 140	-
Юнигаз	-	-	-	-	1 790	-	-	-	-	1 790
Дундаж үнэ	3 710	2 342	2 390	3 640	1 790	3 910	-	2 390	3 140	1 790

Эх сурвалж: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 12-р сарын мэдээ

**Ойлголт, тодорхойлолт:**

**Хэрэглээний сагс:** Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

**Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:** Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

**Хэрэглээний үнийн индекс (ХҮИ):** Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left( \frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left( \frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left( \frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left( \frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

$I_{ct}^L$  – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс  
 t – Тайлант үе  
 0 – суурь үе  
 $P_t^i$  – i барааны тайлант үеийн үнэ  
 $P_0^i$  – i барааны тайлант үеийн үнэ  
 $Q_0^i$  – i барааны тайлант үеийн үнэ


ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.




## АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр

ᠠᠵᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠶᠡᠯᠳᠡᠪᠦᠷᠢᠨ ᠰᠠᠯᠪᠠᠷᠢᠨ ᠨᠢᠶᠲᠤ ᠤᠯᠤᠰᠤ


Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг




Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг



Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг






## АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн байгууллагууд 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1847.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2379.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 13.4 хувиар, борлуулалт 4.5 хувиар өссөн байна.

ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр



Боловсруулах аж үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүнээс өлөн гэдэс үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 64.0 хувь, цагаан архи, хивс, боловсруулсан шингэн сүү, шалны нэхмэл дэвсгэр, соёолжоор бэлтгэсэн шар айрагны үйлдвэрлэлийн биет хэмжээ 0.6-29.8 хувиар тус тус өссөн байна. Харин талх 56.6 хувь, самнасан ноолуур 50.8 хувь, сүлжмэл эдлэл 52.4 хувь, малын мах 69.4 хувь, бусад үйлдвэрлэл 0.8-30 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 18. АЖ ҮЙЛДВЭРИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2023 I-XII	2024 I-XII	$\frac{2024 \text{ I-XII}}{2023 \text{ I-XII}}$
Боловсруулах аж үйлдвэр				
Малын мах	тн	490.5	150.0	-69.4
Өлөн гэдэс	мян.гогцоо	25.6	42.0	64.0
Боловсруулсан шингэн сүү	мян.л	29 221.3	29 396.8	0.6
Талх	тн	5 770.9	2 507.0	-56.6
Нарийн боов	тн	4 098.8	2 868.4	-30.0
Цагаан архи	мян.л	17 269.8	22 420.3	29.8
Соёолжоор бэлтгэсэн шар айраг	мян.л	62 489.9	66 440.9	6.3
Самнасан ноолуур	тн	507.0	249.6	-50.8
Хивс, шалны нэхмэл дэвсгэр	мян.м2	48.6	51.5	6.1
Сүлжмэл эдлэл-ноолуур	мян.ш	180.1	85.8	-52.4
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж				
Цахилгаан эрчим хүч	мян.квт.цаг	1 121 906.0	926 372.9	-0.8*
Дулааны эрчим хүч	мян.гкал	2 983.7	2 579.5	-13.5

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15335.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.5 (18.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1649.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 207.8 (14.4%) тэрбум төгрөгөөр өсөхөд, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 8.9 (6.6%) тэрбум төгрөгөөр, малын тэжээл үйлдвэрлэл 2.1 (31.4%) тэрбум төгрөгөөр, ундаа үйлдвэрлэл 198.0 (43.1%) тэрбум төгрөгөөр, химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 87.1 (76.2%) тэрбум төгрөгөөр, үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэдлмэлийн үйлдвэрлэл 10.9(38.5%) тэрбум төгрөгөөр, машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ 754.1(12.0%) сая төгрөг, бусад боловсруулах үйлдвэрлэл 3.4(17.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл 4.5(8.0%) тэрбум төгрөгөөр, ээрэх, нэхэх, даавуун материал үйлдвэрлэл 50.9(19.7%) тэрбум төгрөгөөр, хувцас үйлдвэрлэл 28.7(14.2%)тэрбум төгрөгөөр, жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт 508.0 (5.8%) сая төгрөгөөр, мах боловсруулах, консервлох үйлдвэрлэл 1.9 (28.0%) тэрбум төгрөгөөр, хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа 1.2 (5.3%) тэрбум төгрөгөөр, резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл 4.1 (40.7%) тэрбум төгрөгөөр, арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 582.1 (2.5%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Цахилгаан, хий, уур, агааржуулалт 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 173.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.6 (7.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 8.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1854.5 (26.8%) сая төгрөгөөр өссөн байна.

Дүүргийн аж үйлдвэрийн салбар 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1847.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 0.8 хувийг, боловсруулах аж үйлдвэрлэл 89.3 хувийг, цахилгаан, хий, уур, агааржуулалт 9.4 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 0.5 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 19. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар, оны үнээр, сая төгрөгөөр

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2023 I-XII	2024 I-XII	<u>2024</u> 2023
	сая төгрөг		
<b>БҮГД</b>	<b>1 629 750.2</b>	<b>1 847 517.9</b>	<b>13.4</b>
<b>УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ</b>	18 845.4	15 335.8	-18.6
Бусад ашигт малтмал олборлолт	18 845.4	15 335.8	-18.6
<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ</b>	1 441 973.3	1 649 748.9	14.4
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	675 759.1	877 988.4	29.9
Мах боловсруулах, консервлэх	6 781.6	4 882.5	-28.0
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	8 810.7	8 302.6	-5.8
Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	136 729.2	145 717.8	6.6
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	57 080.8	52 540.3	-8.0
Малын тэжээл үйлдвэрлэл	6 827.3	8 972.6	31.4
Ундаа үйлдвэрлэл	459 529.5	657 572.6	43.1
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	258 842.9	207 853.9	-19.7
Хувцас үйлдвэрлэл	202 133.4	173 394.1	-14.2
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	23 290.7	22 708.6	-2.5
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	35 248.6	30 647.4	-13.1
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	22 722.7	21 507.6	-5.3
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	114 383.4	201 520.4	76.2
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	28 293.1	39 180.6	38.5
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10 120.4	6 001.5	-40.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	23 313.6	22 793.5	-2.2
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	15 128.4	9 927.0	-34.4
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.5	0.0	-100.0
Тавилга үйлдвэрлэл	6 953.4	6 244.3	-10.2
Бусад боловсруулах үйлдвэрлэл	19 480.7	22 946.1	17.8
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	6 281.4	7 035.5	12.0
<b>ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ</b>	162 017.0	173 664.3	7.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	162 017.0	173 664.3	7.2
<b>УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	6 914.5	8 768.9	26.8
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	6 914.5	8 768.9	26.8

\*дахин их

Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 2379.8 тэрбум төгрөгийг дотоодод, 227.0 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 9.5 хувийг экспортод гаргасан бөгөөд ээрэх нэхэх даавуун материал бэлтгэх үйлдвэрлэлийн 74.1 хувь, нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэлийн 24.8 хувь, ундаа үйлдвэрлэлийн 0.4 хувь, мах боловсруулах үйлдвэрлэл 2.0 хувь, бусад ашигт малтмал олборлолт 1.3 хувь, машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн 9.1 хувь, арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 4.7 хувийг тус тус гадаад борлуулсан байна.

ХҮСНЭГТ 20. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, салбараар, оны үнээр, сая төгрөгөөр

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2023 I-XII	2024 I-XII	2024 2023	Үүнээс: Экспорт (хувиар)
	сая төгрөг			
<b>БҮГД</b>	<b>2 278 389.6</b>	<b>2 379 838.7</b>	<b>4.5</b>	<b>9.5</b>
<b>УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ</b>	18 845.4	22 445.3	19.1	
Бусад ашигт малтмал олборлолт	18 845.4	22 445.3	19.1	1.3
<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ</b>	2 088 535.4	2 172 687.6	4.0	10.4
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1265 087.5	1305 826.8	3.2	0.3
Мах боловсруулах, консервлэх	5 885.3	7 783.7	32.3	2.0
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	9 141.8	8 049.9	-11.9	
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	208 080.8	220 242.5	5.8	
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	61 587.6	64 713.2	5.1	
Малын тэжээл үйлдвэрлэл	6 827.3	7 250.6	6.2	
Ундаа үйлдвэрлэл	973 564.7	997 786.9	2.5	0.4
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	267 142.5	214 581.7	-19.7	74.1
Хувцас үйлдвэрлэл	232 374.9	245 149.6	5.5	24.8
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	23 298.3	26 865.2	15.3	
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	35 404.0	28 437.3	-19.7	
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	34 075.9	30 460.1	-10.6	
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	114 657.6	202 869.1	76.9	
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	31 734.2	38 841.1	22.4	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11 038.1	6 586.0	-40.3	
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	25 586.9	22 795.7	-10.9	
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	15 004.2	13 189.6	-12.1	9.1
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.5	0.0	-100.0	
Тавилга үйлдвэрлэл	6 972.0	7 070.9	1.4	
Бусад боловсруулах үйлдвэрлэл	19 710.6	22 979.0	16.6	
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	6 427.2	7 035.5	9.5	
<b>ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ</b>	162 017.0	173 664.3	7.2	
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	162 017.0	173 664.3	7.2	
<b>УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	8 991.8	11 041.5	22.8	
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	8 991.8	11 041.5	22.8	

\*дахин их

**Ойлголт, тодорхойлолт:**

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

**Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

**Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал:** НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.






## МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО

**Малын тоо, бүтэц:** Хан-Уул дүүрэгт 2024 оны мал тооллогоор нийт 49463 толгой мал тоологдсон нь 2023 оноос 2620 (5.0%) толгой малаар буурсан байна. Нийслэлийн хэмжээнд 2024 онд 412779 толгой мал тоологдсон бөгөөд 12.0 хувийг Хан-Уул дүүргийн мал эзэлж байна.

Зураг 17. ДҮҮРГИЙН НИЙТ МАЛЫН ТОО, оноор



Малын тоог таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад, тэмээ 20 толгойгоор (250.0%) адуу 1477 толгойгоор (8.2%), үхэр 677 толгойгоор (5.4%) өссөн бол хонь 1877 толгойгоор (17.3%), ямаа 2917 толгойгоор (27.3%) тус тус буурсан байна.

Иргэдийн хувийн мал 49087 толгой болж, өмнөх оноос 2157 толгойгоор буурсан бол аж ахуйн

нэгж, байгууллагын мал 376 болж өмнөх оноос 463 толгойгоор буурсан байна.

ХҮСНЭГТ 21. МАЛЫН ТОО, төрлөөр

Малын төрөл	2019	2020	2021	2022	2023	2024	Өсөлт, бууралт	
							Тоо	Хувь
Малын тоо, бүгд	38639	46090	42867	46068	52083	49463	-2620	-5.0
Тэмээ	3	7	11	19	8	28	20	2.5 дах
Адуу	7589	11960	12597	15422	18052	19529	1477	8.2
Үхэр	11845	11900	11214	12293	12481	13158	677	5.4
Хонь	10336	10231	9626	9158	10867	8990	-1877	-17.3
Ямаа	8866	11992	9419	9176	10675	7758	-2917	-27.3
Хонин толгойд шилжүүлснээр*	142523	176179	173621	199223.4	221764.5	231763.2	9998.7	4.5

\* Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ: 5 хонь, 1 адуу: 7 хонь, 1 үхэр: 6 хонь, 1 хонь: 1 хонь, 1 ямаа: 0.9 хонь

2024 онд Хан-Уул дүүргийн 12-р хорооны мал 0.8 хувиар, 13-р хорооных 1.0 хувиар тус тус өссөн бол 14-р хорооны мал 7.9 хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 22. МАЛЫН ТОО, хороогоор

Хороо	2023	2024	Үүнээс: малын төрлөөр					Өсөлт, бууралт, хувь
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
12-р хороо	3712	3743	2	1256	1550	302	633	0.8
13-р хороо	13263	13392	-	2921	5993	2134	2344	1.0
14-р хороо	35108	32328	26	15352	5615	6554	4781	-7.9
Дүн	52083	49463	28	19529	13158	8990	7758	-5.0

Дүүргийн хэмжээнд тоологдсон малын тоогоор 32328 толгой малаар 14-р хороо тэргүүлсэн бол хамгийн цөөн малтай нь 12-р хороо 3743 толгой малтай байна. 2024 онд нийт мал сүргийн 33.9 хувийг бог мал, 66.1 хувийг бод мал эзэлж байна. Нийт мал сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр нь дараах хүснэгтэд харууллаа.

**Мал төллөлт, төл бойжилт:** 2024 онд 12966 хээлтэгч мал төллөж, 12979 төл гарсны 12147 төл (93.6%) нь бойжиж байна. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 4569 толгойгоор (27.3%) буурсан.

ЗУРАГ 18. БОЙЖУУЛСАН ТӨЛ, оноор



ХҮСНЭГТ 23. ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр

	2023	2024	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	17 458	12 979	-	3 153	4 912	2 561	2 353
Бойжсон төл	16 716	12 147	-	3 033	4 751	2 272	2 091
Хорогдсон төл	742	832	-	120	161	289	262
Бойжилтын хувь	95.7	93.6	-	96.2	96.7	88.7	88.9

2024 оны мал тооллогоор нийт 12979 гарсан төлийн 832 (6.4%) толгой нь хорогдож, төл бойжилт 93.6 хувьтай байна. Хорогдсон төл малын тоо 2023 оныхоос 90 толгойгоор өссөн. Нийт хорогдсон төлийн 14.4 хувийг унага, 19.4 хувийг тугал, 34.7 хувийг хурга, 31.5 хувийг ишиг эзэлж байна.

**Том малын зүй бус хорогдол:** Оны эхний малын 9.6 хувьтай тэнцэх 5014 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос хорогдол 3335 толгойгоор нэмэгдсэн. Хорогдсон нийт малын 16.4 хувийг адуу, 11.0 хувийг үхэр, 35.4 хувийг хонь, 37.2 хувийг ямаа эзэлж байна. Том малын зүй бус хорогдлын 4 толгой (0.08%) мал өвчнөөр хорогджээ.

ХҮСНЭГТ 24. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

Үзүүлэлт	2023	2024	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	1679	5014	-	822	554	1775	1863
Үүнээс: Өвчнөөр хорогдсон	6	4	-	-	4	-	-

## ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2024 онд Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 4960 өргөдөл, гомдол ирснээс хуулийн дагуу хугацаанд нь 4866 өргөдөл өгч, шийдвэрлэх хугацаа болоогүй гомдолд хариу 76, шийдвэрлэх хугацаа хэтэрсэн 18 өргөдөл байна.

### ХҮСНЭГТ 25. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ-ын шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга					Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим	Хүсэлт	Гомдол	Талархал	Санал	Мэдэгдэл			
Удирдлага	1	-	1	-	-	1	-	-	-	-	1	-	-
ТЗУХ	75	-	9	65	1	20	48	6	1	-	75	-	-
СТСХ	10	-	2	8	-	2	7	-	1	-	10	-	-
ТГУХ	64	-	12	47	5	29	28	-	7	-	63	1	-
НБХ	28	-	18	10	-	19	4	4	1	-	28	-	-
ТНБХХУХ	472	-	45	411	16	169	279	1	22	1	462	10	-
ХХҮХ	270	-	15	250	5	69	189	-	12	-	268	2	-
ХЭЗАХ	35	-	21	12	2	24	9	-	1	1	35	-	-
Цэргийн штаб	101	-	101	-	-	101	-	-	-	-	101	-	-
<b>ЗДТГ-ын дүн</b>	<b>1056</b>	<b>0</b>	<b>224</b>	<b>803</b>	<b>29</b>	<b>434</b>	<b>564</b>	<b>11</b>	<b>45</b>	<b>2</b>	<b>1043</b>	<b>13</b>	<b>-</b>
Албан бус- НТБ төв	11	-	11	-	-	11	-	-	-	-	11	-	-
Биеийн тамир, спортын хороо	1	-	-	1	-	1	-	-	-	-	1	-	-
Боловсролын хэлтэс	415	-	39	375	1	59	293	48	15	-	412	1	2
Газрын алба	1342	-	925	404	13	1032	294	-	11	5	1329	11	2
ГБХЗХХ	92	-	87	5	-	79	6	1	6	-	91	1	-
НДХ	364	-	67	297	-	69	281	7	7	-	358	5	1
Онцгой байдлын хэлтэс	20	-	1	15	4	12	8	-	-	-	20	-	-
Татварын хэлтэс	760	-	728	31	1	731	27	1	1	-	718	29	13
Цагдаагийн газар	375	-	2	368	5	22	255	97	1	-	364	11	-
ХөХҮХ	412	-	305	103	4	296	105	6	4	1	407	5	-
УБХ	97	-	7	89	1	19	57	16	5	-	97	-	-
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	12	-	11	1	-	12	-	-	-	-	12	-	-
Соёлын ордон	1	-	-	1	-	-	1	-	-	-	1	-	-
Усан спорт сургалтын төв	2	-	-	2	-	-	2	-	-	-	2	-	-
<b>Дэргэдэх хэлтэс, албадын дүн</b>	<b>3 904</b>	<b>0</b>	<b>2 183</b>	<b>1 692</b>	<b>29</b>	<b>2 343</b>	<b>1 329</b>	<b>176</b>	<b>50</b>	<b>6</b>	<b>3 823</b>	<b>63</b>	<b>18</b>
<b>Нийт дүн</b>	<b>4 960</b>	<b>0</b>	<b>2 407</b>	<b>2 495</b>	<b>58</b>	<b>2 777</b>	<b>1 893</b>	<b>187</b>	<b>95</b>	<b>8</b>	<b>4 866</b>	<b>76</b>	<b>18</b>

Танилцуулгыг хянасан:

О.Гэрэл

Б.Тодмаа

Танилцуулгыг бэлтгэсэн:

Ц.Энх-Оюун



Газар тариалан, хөдөө аж ахуй,  
эрүүл мэнд

Ж.Энх-Амгалан



Төсөв, барилга, хэрэглээний үнэ

Б.Тодмаа



Аж үйлдвэр, гэмт хэрэг, инфографик  
мэдээлэл, хавтасны дизайн



Нийгмийн даатгал , нийгмийн халамж

Танилцуулгыг нэгтгэсэн:

Хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Тодмаа

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС